



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2018 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 72

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Жаргалант сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

3 зээлдэгчийн шүүхээр шийдвэрлүүлсэн зээлийн төлбөр болох 2798920 төгрөг өмгөөлөгчийн дансанд орж ирсэн бөгөөд өмгөөлөгч Сум хөгжүүлэх сангийн дансанд хугацаанд нь шилжүүлээгүй.

Энэ нь Өмгөөлөгч хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээний үүргээ зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан"... төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Өмгөөлөгчийн гэрээний үүрэг зөрчсөн 2798920 /хоёр сая долоон ерэн найман мянга есөн зуун хорин/ төгрөгийг Жаргалант сумын Сум хөгжүүлэх сангийн 100031055401 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2018 оны 03 дүгээр сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг

Жаргалант сумын засаг дарга Д.Сайнбилэг, нягтлан бодогч Д.Баттөр нарт хариуцуулав.

АУДИТОР **ТОГТООСОН:** АКТЫГ **ЗӨВШӨӨРСӨН:**

Б.НАРАНГЭРЭЛ **ЖАРГАЛАНТ СУМЫН**
ЗАСАГ ДАРГА
Д.САЙНБИЛЭГ
НЯГТЛАН БОДОГЧ
Д.БАТТӨР

6417143544
 Б-ОА0067 9007423

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.